



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/168, А/191 дүгээр захирамж, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.8-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус /COVID-19/ гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд албан хаагчдыг хамруулан эргүүлээр ажиллуулсугай.

2. Албан хаагчдыг зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын А/168, А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн үүрэг чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ахлах мэргэжилтэн /Н.Пүрэвсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд шаардагдах шатахуун болон бусад зардлыг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Ц.Бямбасүрэн/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

31506000022